



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.07.18 № 01/1546

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Чиглэл хүргүүлэх тухай

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 03/1863 дугаар албан бичгээр Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны “Журам батлах тухай” А/202 дугаар тушаалаар баталсан “Итгэцүүр хэрэглэх журам”-д заасан нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхэд итгэлцүүрийг хэрхэн хэрэглэх талаар чиглэл ирүүлснийг хүргүүлж байна.

1. “2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Нийгмийн даатгалын багц хуулийг буцааж хэрэглэх талаар тусгайлан зохицуулаагүй тул 2024 оноос өмнөх хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхэд тухайн үед мөрдөж байсан хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого зэргийг үндэслэнэ” гэсэн чиглэл ирүүлснийг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

1.1. 2024 оноос өмнө ажил олгочоос даатгуулагчид олгосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл нөхөн ногдуулах тохиолдолд уг цалин хөлсөнд итгэлцүүр хэрэглэхгүйгээр Нийгмийн даатгалын тухай хууль /өмнө нь мөрдөж байсан/-ийн 15 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэгт заасан ажил олгогч болон даатгуулагчийн төлбөл зохих хувь хэмжээгээр шимтгэл ногдуулан, нөхөн төлүүлнэ.

1.2. Нийгмийн даатгалын тухай хууль /өмнө нь мөрдөж байсан/-ийн 15 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэгт заасан ажил олгогч болон даатгуулагчийн төлбөл зохих шимтгэлийн нийт хувь хэмжээг 1995-2017 онд 29.0-31.0 хувь, 2008-2017 онд 21.0-23.0 хувь, 2018 онд 23.0-25.0 хувь, 2019-2020 онд 24.0-26.0 хувь, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд 26.0-29.0 хувь, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 он дуустал хугацаанд 24.0-26.0 хувь байхаар тус тус тооцно.

1.3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль /өмнө нь мөрдөж байсан/-ийн 3 дугаар зүйл, Засгийн газрын 1994 оны 212, 2023 оны 60 дугаар тогтоолоор тус тус баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам” /өмнө нь мөрдөж байсан/-ын дагуу төр, аж ахуйн нэгж, байгууллагаас шимтгэл нөхөн төлүүлэхэд шимтгэл ногдуулах сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тухайн онд улсын хэмжээнд мөрдөж байсан /1995.01-1998.06 сар дуустал 9600 төг,

АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ

1524072106

1998.07-2000.09 сар дуустал 12000 төг ... 2023 онд 550000 төг гэх зэрэг/-аар тооцно.

1.4.Хугацаат цэргийн албыг байлдагч, түрүүчээр хаасан хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэх тохиолдолд тухайн алба хаасан хугацаанд мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын хувь хэмжээгээр шимтгэл ногдуулж, нөхөн төлүүлнэ. Цэргийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Сонсогчийн цэргийн сургуульд суралцсан хугацааг иргэний ажилласан, цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох хугацаанд оруулан тооцно” гэж заасан тул цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэх тохиолдолд мөн баримтална.

1.5.2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө үүссэн шимтгэлийн өрийг төлүүлэх тохиолдолд итгэлцүүрийг хэрэглэхгүй.

2.Хууль тогтоомжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 26<sup>1</sup> дугаар зүйлийн 26<sup>1</sup>.3 дахь хэсэгт “Тухайн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг буцаан хэрэглэхгүй” гэж заасан тул Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 24.1.2, 24.1.4, 24.1.5 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш олгосон цалин, хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн болон шимтгэлийн өрийг төлүүлэхэд мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасан итгэлцүүрийг тус тус хэрэглэнэ.

Өөрөөр хэлбэл Засгийн газрын 2024 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах тухай” 10 дугаар тогтоолоор баталсан 2024 оны цалин хөлсөнд хэрэглэж байгаа итгэлцүүр (1.0)-ийг нэмэгдүүлэн баталсан тохиолдолд хэрэглэнэ.

3.Энэхүү чиглэлд заасан нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлэх тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлд заасан болон Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4. Шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн, хууль бусаар ажлаас халагдсан хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэх тохиолдолд хэдэн оны цалин хөлсийг нөхөн олгосноос хамаарч энэ зөвлөмжийн 1, 2-т дурдсаны дагуу шимтгэлийг тооцон, нөхөн төлүүлнэ. Харин тухайн шийдвэрт тухайн хүний цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод итгэлцүүр хэрэглэхээр тусгайлан заасан тохиолдолд уг шийдвэрийн дагуу цалин хөлсийг итгэлцүүрээр өсгөн тооцож, шимтгэлийг нөхөн төлүүлнэ.

5.”Итгэлцүүр хэрэглэх журам”-ын 2.2-т заасны дагуу цэргийн алба хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол цэргийн алба хаасан хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхэд тухайн иргэний авч байсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нь хэдэн оны цалин хөлснөөс хамаарч энэ зөвлөмжийн 1, 2-т дурдсанаар шимтгэлийг тооцож, нөхөн төлүүлнэ.

Харин Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 21 дүгээр зүйлийн 21.26.2-т “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу цэргийн алба хаасан хугацааг өсгөн тооцсон хугацааны шимтгэлийг шимтгэл төлөх үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс” тооцон төлүүлэхээр заасан тул 2024 онд цэргийн алба хаасан хугацааг энгийн жилд

шилжүүлэн нэмэгдүүлэн тооцох тохиолдолд уг хугацааны шимтгэлийг одоо мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 660 000 төгрөгөөс тооцон төлүүлнэ.

Түүнчлэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаагаар цэргийн алба хаасан иргэн өндөр насны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, эсхүл тухайн иргэн нас барсан бол түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргасан тохиолдолд уг хугацаанд төлөгдсөн байвал зохих шимтгэлтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу нийгмийн даатгалын санд шилжүүлэн төлнө” гэж заасан. Энэ тохиолдолд тухайн иргэний цэргийн алба хаасан хугацаанаас хамаарч энэ чиглэлийн 1, 2-т дурдсаны дагуу шимтгэлийг тооцон, нөхөн төлүүлнэ.

Иймд чиглэл, зөвлөмжийг сайтар судлан, ажил олгогч, даатгуулагч, иргэд, тэтгэвэр авагчдад мэдээлэл хүргэн, хэрэгжилтийг зохион байгуулна уу.  
Хавсралт 1 хуудастай.

ДАРГА



Д.МӨНХЗУЛ



МОНГОЛ УЛСЫН  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5, Утас: 26-15-53,  
Факс: 32-86-34, Цахим шуудан: info@misp.gov.mn  
Цахим хуудас: www.misp.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА Л.МӨНХЗУЛ ТАНАА

2024.06.26 № 03/1863  
танай 2024.04.09 -ны № 01/747 -т

Хариу хүргүүлэх тухай

Тус яаманд ирүүлсэн 2024 оны 01/747 дугаартай албан бичигтэй танилцаж, дараах хариуг хүргүүлэв. Үүнд:

1. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Нийгмийн даатгалын багц хуулийг буцааж хэрэглэх талаар тухайлан зохицуулаагүй тул 2024 оноос өмнөх хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхэд тухайн үед мөрдөж байсан хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого зэргийг үндэслэнэ.

2. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт "Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тохиолдолд шимтгэл ногдох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод энэ хуулийн 22.2-т заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэнэ" гэж заасан.


Хууль тогтоомжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 26 дугаар зүйлийн 26<sup>1</sup>.3 дахь хэсэгт "Тухайн хуульд өөрөөр заагаагүй бол хуулийг буцаан хэрэглэхгүй" гэж заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 24.1.2, 24.1.4, 24.1.5 дахь хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш олгосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхэд хэрэглэнэ.

Энэ тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 44 дүгээр зүйлд заасан хариуцлага тооцно.

Нийгмийн даатгалын байгууллага, улсын байцаагчийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн актыг 2024 онд тогтоох болон хууль бусаар ажлаас халагдсан, хилс хэргээр мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн нь шүүх эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд дээр дурдсаныг баримтлан шийдвэрлэнэ.

Хэрэв шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрт тухайн хүний цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод итгэлцүүр хэрэглэхээр тусгайлан заасан тохиолдолд уг шийдвэрийн дагуу цалин хөлсийг итгэлцүүрээр өсгөн тооцож, шимтгэлийг нөхөн төлүүлнэ.

Хүндэтгэсэн,

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН  
ДАРГА БӨГӨӨД ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.АЛИМАА